| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                           | -             | 9,553,046.0   | (9,553,046.0)  |       |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан / цаашид *Нийтийн номын сан гэх* нь “Номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, номын санг мэдээллийн төв болгон хөгжүүлэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Нийтийн номын сан нь “*Соёлын үнэт зүйл болох ном хэвлэлийн зүйлийг түгээн сурталчлах*” гэж үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.


Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Нийтийн номын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамны “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар”-аас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Соёлын яамны ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын онцлогт тохироогүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,639.0 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт


| Үзүүлэлт                                     | /мянган төгрөгөөр/ |                  |                |
|--|--------------------|------------------|----------------|
|  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт       |
| Б  | 1                  | 2                | 3=2-1          |
| Мөнгөн хөрөнгө                               | -                  | 9,553.0          | 9,553.0        |
| Бараа материал                               | 8,624.7            | 12,012.7         | 3,388.0        |
| Үндсэн хөрөнгө                               | 232,003.3          | 223,701.3        | 8,302.0        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>240,628.0</b>   | <b>245,267.0</b> | <b>4,639.0</b> |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 240,628.0          | 245,267.0        | 4,639.0        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>240,628.0</b>   | <b>245,267.0</b> | <b>4,639.0</b> |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9,553.0 мянган төгрөг болж өссөн нь гүйцэтгэлээр санхүүждэг болсноос шалтгаалан төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,012.7 мянган төгрөг болж 3,388.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 19,859.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, байгууллагын захирлын тайлант оны А/17 дугаар тушаалаар 4,050.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 12,421.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 323,495.1 мянган төгрөг болж 22,407.9 мянган төгрөгөөр өссөн нь 10,077.8 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, ном худалдан авч, 12,330.1 мянган төгрөгийн /иргэн, аж ахуйн нэгж байгууллага, олон улсын байгууллагуудаас/ номыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 245,267.0 мянган төгрөг болж 4,639.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.



### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 306,592.0 мянган төгрөг, нийт зарлагыг 306,592.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт орлого, зардлыг 31,730.0 мянган төгрөгөөр бууруулж, 274,862.0 мянган төгрөгөөр баталсан байна.

2022 оны төсвийн төслийн саналын урсгал үйл ажиллагааны зардлыг бууруулан баталсан нь 5,268.1 мянган төгрөгийг байр ашиглалтын зардлаас, 10,618.9 мянган төгрөгийг хангамж, бараа материалын зардлаас, 8,100.0 мянган төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардлаас тус тус бууруулснаас голлон шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 24,469.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 299,331.4 мянган төгрөг болгож төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 261,874.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 37,456.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 261,874.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 37,456.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 631.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 279,936.8 мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 19,394.6 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| /мянган төгрөгөөр/ |   |            |           |         |         |
|--------------------|---|------------|-----------|---------|---------|
| д/д                | Хөтөлбөр, арга хэмжээ                   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү   | Биелэлт |
| 1                  | Үндсэн үйл ажиллагааны зардал           | 230,725.3  | 223,653.6 | 7,071.7 | 96.9    |
| 2                  | Эрдэм шинжилгээ, судалгааны ажил        | 10,000.0   | 8,457.8   | 1,542.3 | 84.6    |
| 3                  | Ажил олгогчоос олгох тэтгэмж,           | 768.0      | 750.0     | 18.0    | 97.7    |
| 4                  | Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан | 20,381.5   | 14,460.4  | 5,921.1 | 70.9    |
| 5                  | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал   | 24,175.1   | 19,683.6  | 4,491.5 | 81.4    |

|   |                   |                  |                  |                 |             |
|---|-------------------|------------------|------------------|-----------------|-------------|
| 6 | Нийтлэг үйлчилгээ | 13,281.5         | 12,931.5         | 350.0           | 97.4        |
|   | <b>Дүн</b>        | <b>299,331.4</b> | <b>279,936.8</b> | <b>19,394.6</b> | <b>93.5</b> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийтийн номын сан нь нэмэлт санхүүжилтийн дансгүй бөгөөд тайлант оноос эхлэн урсгал зардлын 100130035022 тоот дансаар нэмэлт болон дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан орлогыг авч зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.


Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 247,185.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,707.8

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийтийн номын сан нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлсэн,
- Гар утасны, хэвлэл захиалгын зардлуудыг гаргалгүй хэмнэж ажилласан,
- Сургалт, семинар, хурлыг цахимаар хийж байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Нийтийн номын сан нь мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 166 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол төсөв, өмч хөрөнгө захиран зарцуулан 4,050.3 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар эрхэлж буй ажлыг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр албан хаагчдад 9,406.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон, 3,814.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй гэсэн 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                 | Биелэлт  |                |             |
|-----------------|------------------------|-----------------|----------|----------------|-------------|
|                 | Тоо                    | Дүн             | Тоо      | Дүн            | Хувь        |
| Зөвлөмж         | 2                      | 13,221.3        | 1        | 9,406.4        | 50.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>2</b>               | <b>13,221.3</b> | <b>1</b> | <b>9,406.4</b> | <b>50.0</b> |

Өмнөх онд өгөгдсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн шууд захирагчийн бус Сангийн яамны өгсөн чиглэлээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлийг үүсгэж байна.

Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт шилжүүлсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр эх үүсвэр хэлбэрээр төлөвлөж, зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.

2. Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч соёлын салбарын байгууллагуудын онцлогт тохирохгүй тул Соёлын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн НБББББ-ийг мөрдөх нь зүйтэй.

3. Тайлант онд “81900 соёлын арга хэмжээ”-ний ангилалд зарцуулах эрхийг олговол зохих 10,000.0 мянган төгрөгийн зардлыг “80215 эрдэм шинжилгээ, судалгааны ажил” арга хэмжээний ангилалд баталж, нийтийн номын сангаас зохион байгуулсан уралдаан, тэмцээн, үндэсний бичиг үсэг, номын баяр зэрэг арга хэмжээний зардалд нийт 8,457.7 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг “Эрдэм шинжилгээ, судалгааны ажил” арга хэмжээний зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал” дахь зардлын зориулалттай нийцэхгүй байна. Иймд цаашид үйл ажиллагааны арга хэмжээний зардлын зарцуулах эрхийн төлөвлөгөөг холбогдох ангилалд үнэн, зөв баталж, зарцуулан тайлагнаж байх нь зүйтэй юм.

4. Тус байгууллагын нягтлан бодогч П.Ууганбилэгт улирлын ажлын мөнгөн урамшууллыг тухай бүр олгож байсан боловч аймгийн Засаг даргын 2022 оны А/29 дүгээр захирамжаар санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр албан тушаалын цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр урамшуулал олгохоор шийдвэрлэсний дагуу улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 1,196.5 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан, хууль, эрх зүйн үндэслэлд нийцээгүй урамшуулал олгохгүй байх нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **7,256.0** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,256.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл илүү тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 5,000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөг дутуу тайлагнасан,

Аудитаар нийт 4,470.0 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>2</sup> илэрч 3,670.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 800.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

### 5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 1,870.0 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант оны турш тус байгууллагын гадаад хэлний танхимд иргэн М.Анхбаяр ЕБС-ийн сургагчдад англи хэлний төлбөртэй сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн боловч тус иргэнтэй төрийн өмчийн түрээсийн гэрээ байгуулаагүй буюу 36 метр квадрат талбай бүхий танхимыг үнэ төлбөргүй ашиглуулсан байна. Өөрөөр хэлбэл төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэх төлбөрийн доод хязгаараар тооцож үзвэл тайлант онд 1,800.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг төвлөрүүлэх боломж алдсан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар”-ын 1 дэх “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн доод хязгаарыг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэл зэргийг харгалзан дараах байдлаар тогтооно: 6. Хүүхдийн боловсрол...Аймгийн төв 1 м. кв талбайн түрээсийн төлбөрийн доод жишиг үнэ (төгрөг) 5,000.0” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн төлбөрийн хэмжээ тогтоох зааврыг үндэслэж гэрээ байгуулж, түрээсийн орлогыг хууль, тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

### **5.3 Зөвлөмж**

#### **1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Ажил гүйцэтгүүлэх гэрээ, хүлээн авсан акт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 800.0 мянган төгрөгийн гадаад хэлний танхимын паар солиулах гагнуурын ажил хийлгэсэн байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга  | Нийт алдаа |                | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |                | Үүнээс     |                |              |     |
|--|------------|----------------|-----------------------------------|-----|--------------------------|----------------|------------|----------------|--------------|-----|
|  | Тоо        | Дүн            | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн            | Залруулсан |                | Залруулаагүй |     |
|  |            |                |                                   |     |                          |                | Тоо        | Дүн            | Тоо          | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл илүү тайлагнасан | 1          | 2,256.0        |                                   |     | 1                        | 2,256.0        | 1          | 2,256.0        |              |     |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн төлөвлөгөөг дутуу тайлагнасан           | 1          | 5,000.0        |                                   |     | 1                        | 5,000.0        | 1          | 5,000.0        |              |     |
| <b>Дүн</b>   | <b>2</b>   | <b>7,256.0</b> |                                   |     | <b>2</b>                 | <b>7,256.0</b> | <b>2</b>   | <b>7,256.0</b> |              |     |

/Мянган төгрөгөөр/

4317143998

МЗЭВЛӨМЖ

055430

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                | Зөвлөмж  |              | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|----------|--------------|--------------------------------------|-----|---|-----|
|  | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн | Тоо             | Дүн            | Тоо      | Дүн          | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
|  |             |                |               |     |                 |                |          |              |                                      |     |   |     |
| Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй давтан гаргасан | 1           | 1,870.0        |               |     | 1               | 1,870.0        |          |              |                                      |     |   |     |
| Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан | 1           | 800.0          |               |     |                 |                | 1        | 800.0        |                                      |     |   |     |
| Түрээсийн гэрээ байгуулалгүй сургалтын танхим ашиглуулсан      | 1           | 1,800.0        |               |     | 1               | 1,800.0        |          |              |                                      |     |   |     |
| <b>Дүн</b>   | <b>3</b>    | <b>4,470.0</b> |               |     | <b>1</b>        | <b>3,670.0</b> | <b>1</b> | <b>800.0</b> |                                      |     |   |     |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил   |                | Үүнээс          |     |          |                | Зөвлөмж |
|---|---------------|----------------|-----------------|-----|----------|----------------|---------|
|   | Төлбөрийн акт |                | Албан шаардлага |     | Тоо      | Дүн            |         |
|   | Тоо           | Дүн            | Тоо             | Дүн |          |                |         |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил      | 1             | 4,050.3        |                 |     | 1        | 4,050.3        |         |
| Төсөв, өмч хөрөнгө захиран зарцуулах 1 шийдвэрийг мэдээлээгүй | 1             | 4,050.3        |                 |     | 1        | 4,050.3        |         |
| <b>Дүн</b>  |               |                |                 |     |          |                |         |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                      |               |                |                 |     |          |                |         |
| <b>Дүн</b>  |               |                |                 |     |          |                |         |
| <b>Нийт дүн</b>   | <b>1</b>      | <b>4,050.3</b> |                 |     | <b>1</b> | <b>4,050.3</b> |         |

